



**БАТЛАВ.**  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН  
ХОРООНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ **О.БАТТУЛГА**

**СПОРТЫН ТӨВ ОРДНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ (ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ  
МАТЕРИАЛЫН ХАМТ) ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Спортын төв ордны цэвэрлэгээ, үйлчилгээ (цэвэрлэгээний материалын хамт) /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/

**Төслийн дугаар:** БТСУХ/2023/01/01

**Тендер Шалгаруулалтын арга:** Нээлттэй тендер шалгаруулалт

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС**

Улаанбаатар хот

2023 он

## Нэг. ТЕНДЕРИЙН УРИЛГА

2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Спортын төв ордны цэвэрлэгээ, үйлчилгээ нэмэлт ажил /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/

Тендер шалгаруулалтын дугаар: БТСУХ/2023/01/03

Биеийн тамир, спортын улсын хороо нь эрх бүхий тендерт оролцогчдоос Спортын төв ордны цэвэрлэгээ, үйлчилгээ (цэвэрлэгээний материалын хамт) /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ыг гүйцэтгэх тухай **битүүмжилсэн** тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй
- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2020, 2021 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлнэ.
- Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Шаардахгүй

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Шаардахгүй

Тендерийн хамт 2,130,465 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минут -аас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 10 цаг 20 минут -т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Сүхбаатар дүүрэг 8 хороо бага тойруу 55,  
Спортын төв ордон, 3 давхар, 304 тоот, 51262449

## II БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТӨХ)

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <b>БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>Спортын төв ордны цэвэрлэгээ, үйлчилгээ, нэмэлт ажил (Цэвэрлэгээний материал, ариун цэврийн хэрэглэлийн хамт) /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/</b>
<b>ТШЗ 1.1</b>	Тендерийн урилгын дугаар: <b>БТСУХ/2023/01/01</b>
<b>ТШЗ 1.3</b>	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b>
<b>ТШЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>БТСУХ-ны Урсгал зардал</b>
<b>ТШЗ 2.1</b>	Нийт төсөвт өртөг: <b>56,520,000 төгрөг /тавин зургаан сая таван зуун хорин мянга/ төгрөг</b> <b>2023 оны санхүүжих дүн: 56,520,000 /нэг зуун тавин есөн сая дөчин зургаан мянга таван зуун төгрөг/</b> <b>Ажил гүйцэтгэх хугацаа: 2023 оны 04 дүгээр сараас 12 дугаар сарыг дуустал байна.</b>
<b>Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА</b>	
<b>ТШЗ 8.2</b>	Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: <b>Хүлээн авагчийн нэр: БТСУХ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Г.Базархүрэл</b> <b>Хаяг: Спортын төв ордон, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Улаанбаатар, Монгол Улс</b> <b>Утасны дугаар: 51262449</b> <b>Цахим шуудангийн хаяг: bazarkhurel@sport.gov.mn</b>
<b>ТШЗ 9.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>Тийм</b>
<b>В. ТЕНДЕР БЭЛТГЭХ</b>	
<b>ТШЗ 12.2</b>	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>Монгол</b>

ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>Зөвшөөрөхгүй</b>
ТШЗ 17.2	<p>Тендерт оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>Санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтооход ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай шалгуур үзүүлэлтийг тусгах ба хувь хэмжээг үндэслэлгүй тогтоохгүй байхыг анхаарна уу. Тавигдах шаардлагын жишээ нь дараах байж болох боловч үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Борлуулалтын орлогын хэмжээ: 50 хувиас багагүй байх</b></li> </ul>
ТШЗ 17.2.5	<p>Санхүүгийн чадавхын талаар энэ зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангах бусад баримт: <b>Шаардана</b></p> <p>1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 20 хувиас багагүй байна.</p> <p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/</li> <li>- Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;</li> </ul> <p>2. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, эзлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ</p>
ТШЗ 17.3	Тендерт оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: <b>2020, 2021 он</b>
ТШЗ 17.6	<p>Тендерт оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага:</p> <p><b>[Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг тогтоохдоо тухайн ажлын онцлог, тоо хэмжээг харгалзан зайлшгүй шаардлагыг тусгана. Тухайлбал дараах шаардлагууд байж болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:</b></p> <p><b>Ижил төстэй гэрээний туршлага: Сүүлийн 2 жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх /гэрээний хуулбарыг хавсаргана/</b></p>
ТШЗ 17.6.1	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>Шаардахгүй</b>
ТШЗ 17.6.2	<p>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл: <b>Шаардана</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажилчдаа ижилсүүлсэн үйлчилгээний өнгө төрхийг илэрхийлсэн нэр лого бүхий хувцас хэрэгслээр хангасан байх, /зураг хавсаргах</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн үзлэгт хамруулж эрүүл мэндийн дэвтэр хөтөлсөн байх /бактериологийн шинжилгээ/</li> </ul>
<b>ТШЗ 17.6.3</b>	<p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: <b>Шаардана</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тоос сорогч</li> <li>- Плита, паркет өнгөлгөөний машин</li> <li>- Цонх, хулдаасан шал угаах багаж хэрэгсэл</li> <li>- Уурын цэвэрлэгээний төхөөрөмж гэх мэт тоо ширхэг, зургийг хавсаргах</li> <li>- Бусад танай байгууллагад хэрэглэгддэг төхөөрөмжүүдийн жагсаалт, тоо ширхэг, хүчин чадлын мэдээлэл /зураг хавсаргах/</li> <li>- Цэвэрлэгээний иж бүрдэл бүхий тэргэнцэр /Анхааруулга тэмдэг/халдвартай ба халдваргүй бүсийг ялгах/, шүүр, хутгуурын хамт, шалны сойтог, шил цонх арчигч, шал угаах зориулалтын мод алчууртай, шал угаах хувин, тоосны хувин, алчуурын хамт, шпатель г.м /</li> </ul>
<b>ТШЗ 17.6.4</b>	<p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний мэдээлэл: <b>Шаардлагатай</b></p>
<b>ТШЗ 17.6.5</b>	<p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримт: <b>Шаардана</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Татвар, нийгмийн даатгалын үлдэгдэлгүйг нотолсон тодорхойлолт</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>- Харилцагч банкуудын өр, авлагагүй эсэх талаар тодорхойлолт.</li> <li>- Сүүлийн 1 жилийн хугацаанд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагатай байх ба туршлагыг нотлох гэрээ, гэрээ дүгнэсэн акты хуулбар ирүүлнэ.</li> <li>- Цэвэрлэгээний хуваарь гаргах, нэг сард хэрэглэх цэвэрлэгээний материал, халдваргүйжүүлэлтийн болон угаалгын бодисны жагсаалт, тооцоог хавсаргах</li> <li>- Голлон хариуцаж ажиллах менежер, ажилтны мэдээлэл, танилцуулга /мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар/-ыг ирүүлнэ.</li> <li>- Компаний ерөнхий мэдээлэл, танилцуулгыг ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогчийн төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж, нотариатаар баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>- Ажил гүйцэтгэх үнийн саналаа маягтын дагуу ирүүлэх, ажлын үнийн саналд техникийн тодорхойлолтод тусгагдсан зардлыг багтаана.</li> </ul> <p>Дээрх тодорхойлолтод, албан бичгүүд нь эх хувиараа байх ба тендер зарлагадаж байгаа хугацаанд авсан байх шаардлагатай.</p>

<b>ТШЗ 17.7.</b>	Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>Шаардана</b>
<b>ТШЗ 19.5.</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>Тохируулахгүй тогтмол байна</b>
<b>ТШЗ 22.1</b>	Тендерийн баталгаа: <b>Шаардана”</b> <i>Тендерийн баталгаа: Төсөвт өртгийн 1% буюу 2,130,046 /хоёр сая нэг зуун гучин мянга дөчин зургаан төгрөг/</i>
<b>Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ</b>	
<b>ТШЗ 23.5.3</b>	ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан болон V бүлгийн маягтуудаас гадна бусад тендерт оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>- Татвар, нийгмийн даатгалын үлдэгдэлгүйг нотолсон тодорхойлолт</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газрын тодорхойлолт</li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>- Харилцагч банкуудын өр, авлагагүй эсэх талаар тодорхойлолт.</li> </ul>
<b>ТШЗ 24.1.</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2023.04.13</b> Цаг: <b>10:00</b>
<b>ТШЗ 26.1.</b>	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: <b>2023.04.13</b> Цаг: <b>10:20</b> Тендер нээх газрын хаяг: <b>Спортын төв ордон 304 тоот</b>
<b>Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ</b>	
<b>ТШЗ 30.2</b>	Үнэлгээнд харгалзах нэмэлт шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: <b>Ашиглахгүй</b>
<b>Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ</b>	
<b>ТШЗ 39.1</b>	Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: <b>Тийм</b> <b>ТШЗ-ны 7.5-д заасан гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ</b>
<b>Ё. БУСАД</b>	
<b>ТШЗ 41.1</b>	Урьдчилгаа төлбөр олгох эсэх <b>Үгүй</b>

<b>ТШЗ 43.1</b>	Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдаж байгаа эсэх: <b>Үгүй</b>

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### *Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж*

*[Захиалагч болон үнэлгээний хороо нь ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд захиалагчийн зураг төсөл (техникийн болон ажлын зураг, өртгийн төсөв), ажлын хуваарь, тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулан, уг барилга байгууламжийг ашиглалтад бэлэн болгохтой холбоотой ажил, бараа, үйлчилгээнд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.*

*Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах бараа, үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.*

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.*
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.*
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.*
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана.*
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.*
- Бараа материалын техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.*
- Ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын хувьд санал болгох бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.*

*Зураг төсөл, загвар зураг*



Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.

### Шалгалт, туршилт

Захиалагч тендерт оролцогчоос тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно.

Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгыг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.

### Үе шатны ажлын хуваарь

Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана.]

Ажлын талбай	Шалны талбай	Давтамж	Цэвэрлэгээ хийх хэсэг
Гадна талбайн цэвэрлэгээ	1080м2	Өдөрт 1-2 удаа	Спортын төв ордны гадна талбай, довжоо, ар талбын талбай
3-4 давхар	1431.9 м2	Өдөрт 1-2 удаа	401-409 тоот өрөө, 4 давхрын 5 ширхэг коридор, хурлын заал, шат, 301-321 тоот өрөө, 3 давхрын коридор
А заал	382,6 м2	Өдөрт 1-2 удаа	Үзэгчдийн суудал, талбай
А заал	382,6 м2	Өдөрт 1-2 удаа	Үзэгчдийн суудал, талбай
А заал	382,6 м2	Өдөрт 1-2 удаа	Үзэгчдийн суудал, талбай
00-ийн үйлчилгээ	278 м2 38 суултуур	Өдөрт 1-2 удаа	1-4 давхрын болон тамирчдын эр,эм 00 өрөөний шал, хана, суултуур, угаалтуур, эрэгтэй писсаур
Чөлөөт бөхийн болон самбо бөхийн заал	461,4м2	Өдөрт 1-2 удаа	Чөлөөт бөхийн заал /эрэгтэй/, самбо бөхийн заал
Б заал	1148м2	Өдөрт 1-2 удаа	Б заалны талбай, дэвжээ хулдаас
Чөлөөт бөхийн заал	414,5м2	Өдөрт 1-2 удаа	Чөлөөт бөхийн заал /эмэгтэй/, багшийн өрөө, шат, шатны талбай, Б заалны цайны газар хүртэлх коридор
Хүндийн өргөлт, боксын заал	426,4м2	Өдөрт 1-2 удаа	Хүндийн өргөлтийн заал, боксын заал, багш нарын өрөө, коридор
1 давхарын вестибюль	374,9 м2	Өдөрт 1-2 удаа	1 давхарын вестибюль, коридор, алаг чулуун шат, 1- 3 давхарын шат
Саун	510 м2	Өдөрт 1-2 удаа	Эр, эм саун, коридор, сауны хана, шал, 00
А заал			Бүх төрлийн уралдаан тэмцээн зохион байгуулах үеийн цэвэрлэгээ үйлчилгээ, уг ажлын тоо хэмжээнд нэмэлтээр хамаарна.

- Өдрийн 8 цагийн жижүүр-1, слесерь дулааны улиралд өдрийн 8 цагаар 1, хүйтний улиралд 4 ээлжээр, нийт 6 хүн ажиллуулна.
- Цэвэрлэгээний материал
- Үнийн саналыг хамтад тооцож ирүүлнэ.